



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/821

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалыг тус тус үндэслэн захирамжлах нь:

1. Байгалийн нөөц баялаг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд:

- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн
- Мэргэжлийн хяналтын газрын геологи, уул уурхайн асуудал хариуцсан хяналтын улсын байцаагч
- Сав газрын захиргааны ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн
- Тухайн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Тухай сумын байгаль хамгаалагч
- Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий түүний баялагийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Zax A/821 Ch

02 04015

2. Байгалийн нөөц баялаг ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, дүгнэлт гарган дүнг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн даргад даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Ц.Ганданповрон/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ